

**"Жуулчин говь" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
Ээлжит хурлын тэмдэглэл**

2021-04-26

Улаанбаатар хот

"Жуулчин говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цаг үеийн онцгой нөхцөл байдлын улмаас 2021 оны 4 дүгээр сар 26-ны өдрийн 13.00-14.00 цагийн хооронд Цахим хэлбэрээр хийлээ.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Хурлын дэгийг танилцуулаад саналаа өгнө үү? Гэхэд Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хурлын дэгийг баталлаа.

Нарийн бичгийн дарга С.Батбилэг хурлын ирцийг танилцуулав.

С.Батбилэг: "Жуулчин говь" ХК-ийн хувьцааны 67660 ширхэг хувьцааг эзэмшигч 5 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон ба 71,85 хувийн ирцтэй байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр заалтыг үндэслэн ирц хангалттай гэж үзээд хурлыг эхлүүлж байна.

Хурлаар хлэлцэх асуудлууд:

-Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

- Компанийн ТУЗ-ийн 2020 оны тайлан

- Аудитын хорооны тайлан

- ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааны тайланг П.Мөнгөнцэцэг танилцуулна. /Хурлын материалд тайланг хавсаргав/

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Тайлангуудаа сонссоны дараа асуулт, хариултаа явуулахуу гэсний дагуу Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар дараа нь асуулт хариулт явуулахаар болов.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

/Хурлын материалд тайланг хавсаргав/

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Аудитын хорооны тайланг танилцуул гэв.

Аудитын хорооны гишүүн Ө.Будханд Аудитын тайланг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав/

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Тайлангуудаа сонслоо. Асуулт хариултаа эхэлье гэв.

Д. Хуушаан: За 2020 оны тайланг сонслоо. Цар тахалын улмаас орлого гээд байх юм ороогүй юм байна. 2021 онд яая гэж бодож байна.

П.Мөнгөнцэцэг: Одоогийн байдлаар тодорхойгүй байна. Энэ жилийн хувьд хил нээгдээд Жуулчин ирдэг юмаа гэхэд хэд хэдэн шаардлагыг хангах хэрэгтэй болж байгаа. Хэрвээ жуулчин авахаар бол гадаад жуулчин, дотоод жуулчин авна гэдгээрээ хязгаарлалт тогтооно. Жишээ нь гадаад жуулчин авбал дотоодоо авахгүй гэсэн үг. Мөн жуулчин авах хүчин чадлынхаа тал хувиар жуулчин авна гэх зэргээр шаардлагууд байна. Бид захиалга тодорхой биш учраас хэзээ хэдэн хүн ирнэ гэж гарахуу урьдчилж таамаг гаргах нөхцөлгүй болохоор эрсдэлтэй байна.

Д.Мөнхсайхан: Энэ жил ч бас хэцүү л байна байхдаа. 2 манаач байгаа юу.

П.Мөнгөнцэцэг: 2 бааз дээр тус тус 11 манаач байгаа.

Ч.Тогтохбаяр: Монгол жуулчид ер нь хээрээр л аялдаг байхдаа .

П.Мөнгөнцэцэг: Засгийн газар, Аялал жуулчлалын яамнаас "Хямд амар" аяныг өрнүүлж дотоодын жуулчдыг тал үнээр авах аян өрнүүлж байгаа боловч гарах зардлыг тооцож үзэхэд эрсдэл өндөртэй байна. Тэгээд ч манайхан хээрээр л майханд хоноглож аялж байнадаа. Энэ жил бас л хэцүү болж байна.

Г.Мөнхбилэг: За ер нь энэ жил ч бас л ойлгомжтой боллоо доо. Санхүүгийн асуудал хүндэрч эхэлхэнэдээ. Өөр санал хүсэлт байна уу. За алга байх шиг байна. Хурлаа цааш нь үргэлжлүүлий.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг сонгоё. ТУЗ-ийн гишүүдэд өөрчлөлт орсон. 2 гишүүн өөрчлөгдсөн гээд ТУЗийн гишүүдийн танилцуулгыг хийв.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Хурлын дэгийн санал авсан байгаа. П.Мөнгөнцэцэг саналын дүнгээ танилцуул гэв.

П.Мөнгөнцэцэг: Санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төслийг танилцуулав.

1. Саналын хуудсаал Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн байна.

2. ТУЗийн гишүүнд нэр дэвшигч Д.Хуушаан, Д.Ганболд, Д.Мөнхсайхан, А.Цэцэгдэлгэр, Ч.Тогтохбаяр, Ж.Одонбаяр. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Г.Мөнхбилэг, Э.Мөнхсайхан, Ө.Будханд нар 67660 ширхэг санал буюу 100 хувь тус тус санал авсан байна.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: "Жуулчин говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүдийг танилцуулж баталлаа.


1. Тогтоол №1 Тайлан батлах /2020 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайлан/

2. Тогтоол №2 ТУЗ-ийн гишүүдийг батлах

Хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа, та бүхэндээ эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хурлыг 14.00 цагт хаав.

Хянасан хурлын дарга



Г.Мөнхбилэг

Тэмдэглэл хөтөлсөн -2



С.Батбилэг